



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих Тавантолгой 450 МВт-ын дулааны цахилгаан станцын эхний ээлжийн 300 МВт-ын гүйцэтгэгч болон санхүүжүүлэх эх үүсвэрийг сонгон шалгаруулах тендер;

Тендер шалгаруулалтын дугаар: ЭХЯ/202306001;

Эрчим хүчний яам нь эрх бүхий тендерт оролцогчдоос Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих Тавантолгой 450 МВт-ын дулааны цахилгаан станцын эхний үе шатны 300 МВт-ын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх, ашиглалтад хүлээлгэн өгөх битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерт оролцогч нь тендерт оролцох хүсэлтээ албан бичгээр tender@tttp.mn цахим хаягт илгээх бөгөөд тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 5,000.0 ам.доллараар урилгад заасан хаягаас худалдан авна.

Тендерт оролцогч нь албан бичигт холбоо барих итгэмжилсэн хүний овог нэр, холбоо барих утасны дугаар, цахим хаягийг /Монгол Улсын цахим хаягнаас саадгүй харилцах/ тодорхой тусгасан байна.

Тендерийн баримт бичгийн үнийг дараах мэдээллийн дагуу шилжүүлнэ үү.

Дансны дугаар: 5038 999 444

Хүлээн авагчийн нэр: "ТАВАНТОЛГОЙ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ"

Хүлээн авагч банк: ХААН БАНК

Swift code: AGMOMNUB

Тендерийг **2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 11.00 цагаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 12.00 цаг-т** нээнэ. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг мөн хаягаар авч болно.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Хаяг: Монгол Улс, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, "Их Монгол Улс" гудамж, Сакура Тауэр, 902 тоот

Утас: +976 78110003

Вебсайт: www.tttp.mn

Цахим хаяг: tender@tttp.mn